МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГТЭЙ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХАМГААЛЛЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны төрөл:	**Харьцуулсан судалгаа**
Судалгааны код:	**СТ-25/217**
Хугацаа:	**2025.04.15**

ЗАХИАЛАГЧ:	УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал
Хянасан:	ПСХХ–ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт
	ПСХХ–ийн Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр
Судалгаа удирдсан:	Нийгмийн судалгааны хэсгийн эрхлэгч Э.Дашзэгвэ
Судлаач:	Нийгмийн судалгааны хэсгийн референт Б.Батцэцэг

Улаанбаатар хот
2025

АГУУЛГА

АГУУЛГА 2
Хүснэгтийн жагсаалт 3
Товчилсон үгс 3
УДИРТГАЛ 4
Түлхүүр үг: 4
НЭГ. МОНГОЛ УЛСЫН АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГТЭЙ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХАМГААЛЛЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ 5
1.1. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц 6
1.2. Монгол Улсын аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн эрхийн хамгаллын хүрээний хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлт 8
ХОЁР. ЗАРИМ ОРНЫ АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГТЭЙ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХАМГААЛЛЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ 11
2.1. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийг үл алагчлах 11
2.2. Хууль эрх зүйн орчин 13
2.3. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдэд зориулсан боловсрол 16
2.3.1. Америкийн Нэгдсэн Улс (АНУ) 16
2.3.2. Бусад орнуудын АХЭ-тэй хүүхдэд зориулсан боловсрол 18
2.3.3. Зарим улсын аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн сургалтын үйл ажиллагааны онцлог 19
2.4. Аутизмын хүрээний эмгэгтэй хүний дундаж наслалт 19
2.5. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээ 20
2.5.1. Америкийн Нэгдсэн Улс (АНУ) 20
2.5.2. Бусад орнуудын аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдэд үзүүлдэг эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ 21
2.6. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн гэр бүлд төрөөс олгодог нийгмийн халамжийн төрөл 23
2.6.1 Америкийн Нэгдсэн Улс (АНУ) 23
2.6.2 Бусад орнуудын АХЭ-тэй хүүхдийн гэр бүлд төрөөс олгодог нийгмийн халамжийн төрөл 24
СУДАЛГААНЫ ҮР ДҮН 28
НОМ ЗҮЙ 29

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлт..... 8
Хүснэгт 2. Бусад орны хууль тогтоомж..... 13
Хүснэгт 3. Бусад орны эрүүл мэнд, нийгмийн халамжийн тэтгэмж..... 22
Хүснэгт 4. АХЭ-тэй хүний дундаж наслалтын үзүүлэлт..... 20
Хүснэгт 5. АНУ нийгмийн халамжийн төрөл..... 23
Хүснэгт 6. Бусад орны нийгмийн халамжийн төрөл..... 25

Товчилсон үгс

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХЭ	Аутизмын хүрээний эмгэг
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
СЭМҮТ	Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
DSM	Аутизмын хүрээний эмгэгийн оношилгооны стандарт
EIS	Эрт интервенцийн үйлчилгээ
AAC	Бусад нэмэлт харилцаа холбоо
ABA	Хэрэглээний зан үйлийн шинжилгээ

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын захиалгаар “Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн эрхийн хамгааллын талаарх харьцуулсан судалгаа”-г Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн эрхийн хамгааллын талаарх олон улсын зөвлөмж болон зарим орны хууль эрх зүйн орчин, тэдэнд үзүүлж буй нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээ болон гэр бүлд нь төрөөс олгодог нийгмийн халамжийн төрлийн талаар харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд аутизмын хүрээний эмгэгийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоо, эрт үеийн оролцоо, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын жишиг болохуйц тогтолцоотой Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Австрали, Өмнөд Солонгос, Герман, Их Британи, Швед, Япон зэрэг улсуудыг харьцуулан судаллаа.

Судалгааны бүтэц: Судалгааны тайлан үндсэн хоёр хэсэгтэй. Үүнд:

Нэг. Монгол Улсын аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн эрхийн хамгааллын хууль эрх зүй:

- Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц;
- Монгол Улсын хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлт.

Хоёр. Зарим орны аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн эрхийн хамгааллын хууль эрх зүй:

- Үндэсний хууль тогтоомж;
- Боловсролын тогтолцоо;
- Эрүүл мэндийн үйлчилгээ;
- Нийгмийн халамж;
- Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн гэр бүлд төрөөс үзүүлдэг нийгмийн халамж.

Судалгааны бүтцийн хувьд дурдсан асуудал тус бүрийг хоёр бүлгийн найман дэд бүлэгт багтаан дарааллын дагуу бүлэглэж, тухайн асуудлаар харьцуулан жишсэн тоон мэдээлэл, сайн туршлагын жишээ, баримтыг дурдаж, ижил төстэй шинжээр нь ангилан бүлэглэсэн байдлаар оруулсан болно.

Судалгааны арга зүй: Судалгааг олон улсын гэрээ, конвенц, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын судалгааны ажлын тайлан, зөвлөмж, болон тухайн улсын холбогдох үндэсний хууль тогтоомж, нийгмийн халамжийн байгууллага, эрүүл мэндийн байгууллагуудын холбогдох мэдээллийг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглан гүйцэтгэв.

Түлхүүр үг:

Монгол: *аутизмын эмгэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, аутизмын ангилал, сэтгэцийн эмгэг өөрчлөлт, сэтгэцийн эрүүл мэнд*

Англи: *autism spectrum disorder, person with a disability, types of autism spectrum disorder, mental disorder, psychological condition, mental health*

НЭГ. МОНГОЛ УЛСЫН АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГТЭЙ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХАМГААЛЛЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага (ДЭМБ)-аас тодорхойлсноор ***Аутизмын хүрээний эмгэг (АХЭ)*** (Autism Spectrum Disorder (ASD)) гэдэг нь аутизм ба аспергерийн хам шинжийг хамардаг бөгөөд энэ эмгэг нь нийгмийн харилцаа, үгэн болон үгэн бус харилцааны алдагдал, мөн давтагдмал зан үйл зэргээр илэрдэг бөгөөд илрэх түвшин, хэлбэр нь хүн бүрт харилцан адилгүй байдаг (WHO, 2023).

Энгийн үгээр тодорхойлбол, аутизмын хүрээний эмгэг нь хүний бусадтай харилцах, нийгмийн харилцаанд орох, мэдээллийг хүлээж авч боловсруулах чадварт нөлөөлдөг насан туршийн өргөн хүрээний эмгэг юм (Монголын Аутизмын Холбоо).

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн шийдвэрээр 2008 оноос эхлэн жил бүрийн 4 дүгээр сарын 2-ны өдрийг "Аутизмыг таниулах дэлхийн өдөр" болгон тэмдэглэн ирсэн.

Монгол Улс 2008 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц"-д нэгдэн орсноор 2010 оноос эмч мэргэжилтнүүд АХЭ-ийн талаар илүү анхаарах болж, 2016 онд "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль"-ийг шинэчлэн найруулахдаа "хөгжлийн бэрхшээлтэй хүн" гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ хэмээн АХЭ-ийг хөгжлийн бэрхшээлд хамруулж үзэх болсон.

Зураг 1. Монгол Улсын АХЭ-ийн оношилгоо (2019-2023 он)

Эх сурвалж: АХЭ-тэй хүүхдийн эрүүл мэндийн асуудал (СЭМҮТ, 2024)

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (СЭМҮТ) болон бусад эмнэлэгт улсын хэмжээнд 2019 онд АХЭ-тэй гэж 371 хүүхэд оношлогдож байсан бол 2023 оны байдлаар 1980 хүүхэд АХЭ-тэй гэж оношлогдсон. Аутизмын хүрээний эмгэгийн оношилгооны

төлбөрийн 70 хувийг Эрүүл мэндийн даатгалаас төлдөг болсноор эрт үеийн оношилгоо, үзлэгийн тоо нэмэгдэхийн хэрээр илрүүлгийн тоо нэмэгдэж буй нь харагдаж байна.[1]

> АШУҮИС-ийн клиникийн профессор, хүүхдийн сэтгэцийн эмч Д.Энхтуяа: *“2008 онд аутизмын нэг тохиолдол гарахад манай сэтгэцийн эмч нар гайхаж хүлээж авч байлаа. Бид АШУҮИС-ийн эмч нартайгаа хамтраад тухайн үедээ хүүхдэд эрт илэрдэг шизофрени юм болов уу гэж л оношилж байсан юм. Анх ингэж л энэ өвчинтэй танилцаж, мэдээлэл авч байлаа”*

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 100 хүүхэд тутмын нэг нь АХЭ-тэй гэж тооцоолж байгаагаас АХЭ нь эрүүл мэндийн тулгамдсан асуудал мөн гэж үзэж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг улс орнуудад зөвлөсөн байна (WHO, 2023). Үүнд:

- Эрт илрүүлэх, оношлох;
- Нотолгоонд суурилсан арга хэмжээ, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх;
- Хүртээмжтэй боловсрол олгох;
- АХЭ-тэй хүүхдийн гэр бүлд дэмжлэг үзүүлэх;
- АХЭ-ийн талаар олон нийтэд мэдлэг мэдээлэл түгээх;
- Нийгмийн үйл ажиллагаанд АХЭ-тэй хүнийг тэгш хамруулах;
- АХЭ-ийн талаар судалгаа, мэдээлэл хийх;
- Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг бэлтгэх;
- АХЭ-тэй хүмүүсийн эрхийг хамгаалах хууль, бодлого боловсруулах;
- Улс орнуудын хамтын ажиллагааг дэмжих.

1.1. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц

Монгол Улс АХЭ-тэй хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой дараах олон улсын гэрээ, конвенцод албан ёсоор нэгдэн орж соёрхон баталснаар олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө дараах үүргүүдийг хүлээсэн байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц[2] *(Convention On The Rights Of Persons With Disabilities)*. Тус конвенцод нэгдсэн улсууд хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүсийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг ялгаварлалгүйгээр бүрэн хэрэгжүүлэх, баталгаажуулах, дэмжих үүрэг хүлээнэ. Тухайлбал:

- Шаардлагатай бүх хууль эрх зүйн, захиргааны болон бусад зохих арга хэмжээг батлах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхаж буй одоо мөрдөгдөж буй хууль, журам, зан заншил, дадал хэвшлийг өөрчлөх, хүчингүй болгох, зохих арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Бүх бодлого, хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, дэмжих асуудлыг харгалзан үзэх;
- Конвенцын заалтад нийцэхгүй аливаа үйл ажиллагаа, дадал хэвшлээс татгалзах, мөн төрийн болон төрийн бус байгууллагуудыг энэхүү конвенцын хүрээнд ажиллах нөхцөлийг хангах;

[1] Монгол Улс (2022). Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/53 дугаар тушаалын хавсралт. Хандах: https://emd.gov.mn/legals/647
[2] United Nations Convention On The Rights Of Persons With Disabilities (2006). Хандах: https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/convention-rights-persons-disabilities. Хандсан огноо: 2025-03-06.

- Хувь хүн, байгууллага, хувийн хэвшлийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн ялгаварлалын бүх хэлбэрийг устгах, зохих арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Бүх нийтэд зориулан зохион бүтээсэн бараа, үйлчилгээ, тоног төхөөрөмж, судалгаа, хөгжүүлэлтийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцгой хэрэгцээнд нийцүүлэн хамгийн сайнаар, хамгийн бага зардал шаардагдах байдлаар хөгжүүлж, ашиглалтыг дэмжих, стандарт, удирдамжид бүх нийтийн загварын үзэл баримтлалыг тусгах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиромжтой мэдээлэл, харилцаа холбооны технологи, хөдөлгөөнт туслах хэрэгсэл, тоног төхөөрөмж, дэмжих технологийг судлах, хөгжүүлэх, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, ашиглалтыг дэмжих, эдгээрийн үнийг боломжийн түвшинд байлгахыг тэргүүлэх чиглэл болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөдөлгөөнт туслах хэрэгсэл, тоног төхөөрөмж, шинэ технологи зэрэг дэмжлэгийн хэлбэрүүд, үйлчилгээ, байгууламжийн талаар хүртээмжтэй мэдээлэл олгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллаж буй мэргэжилтэн, ажилтнуудыг сургаж, тэдний эрхийг хангах тусламж, үйлчилгээг илүү үр дүнтэй үзүүлэх боломжийг бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

2. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц[3] (*United Nations Convention on the Rights of the Child*)-ийн дагуу тухайн улсад оршин суугаа хүүхэд бүр энэхүү Конвенцид заасан эрхийг ялгаварлалгүйгээр эдлэх ёстой. Хүүхэд болон түүний эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, гэр бүлийн бусад гишүүн арьс өнгө, хүйс, хэл, шашин, үзэл бодол, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэндийн байдал зэрэг шалтгаанаар ямар нэгэн хэлбэрээр алагчлагдах ёсгүй. Түүнчлэн эдгээр шалтгааны улмаас ялгаварлан гадуурхах, шийтгэхээс хамгаалах бүхий л зохистой арга хэмжээг улс орнууд авах үүрэгтэй.

3. Саламанкын тунхаглал[4] (*Salamanca Statement 1994*) нь хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийг *хамран сургалтын (inclusive education)* тогтолцоонд хамруулах олон улсын бодлогын үндэс болсон. Энэхүү тунхаглалд нэгдсэн орнуудад дараах үүргийг хүлээлгэсэн. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй[5] болон тусгай хэрэгцээт[6] боловсрол шаардлагатай бүх хүүхдийг ердийн сургуулийн орчинд суралцах боломжийг бүрдүүлэх;
- Боловсролын хууль тогтоомжийг шинэчилж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ялгаварлахгүй байх, чанартай боловсрол эзэмших эрхийг нь баталгаажуулах;
- Тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр багш, сургалтын ажилтнуудыг бэлтгэх, мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын хэрэгцээнд нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг уян хатан, хүртээмжтэй болгох;

[3] United Nations Convention on the Rights of the Child (1989). Хандах: https://www.unicef.org/child-rights-convention. Хандсан огноо: 2025-03-01.
[4] UNESCO (1994). Salamanca Statement and Framework for Action on Special Needs Education. Хандах: https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000098427. Хандсан огноо: 2025-03-02.
[5] хөгжлийн бэрхшээлтэй хүн: Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой хүнийг хэлнэ. (НҮБ, 2006)
[6] тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд: хөгжлийн бэрхшээлтэй, хараа хяналтгүй, алслагдмал болон нүүдэлчин өрхийн, хэл соёл ба үндэсний цөөнхийн, шашин шүтлэг зэргээс үл хамааралтай, ялгаварлаг гадуурханлсан……хүүхдийг хэлнэ. (UNESCO, 1994)

- Барилга байгууламж, мэдээлэл, технологи, харилцаа холбооны хэрэгслийн хүртээмжийг сайжруулах (жишээлбэл, ном, сурах бичиг, дижитал хэрэглэгдэхүүн, харилцаа холбооны хэрэгсэл);
- Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай сурагчдад зориулсан мэргэшсэн дэмжих үйлчилгээг (жишээ нь, туслах багш, дэмжлэгийн анги, сэтгэл зүйч, туслах технологи гэх мэт) бий болгох;
- Хамран сургах тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт боловсролын хөрөнгө оруулалтыг дэмжих;

4. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд (UNDP, 2025) - АХЭ-тэй хүмүүсийн боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын асуудлыг онцлон тэдний тэгш эрхийг дэмжих амлалт өгсөн.

- 4-р зорилт: Чанартай, хүртээмжтэй боловсролыг бүх хүнд олгох;
- 8-р зорилт: Тогтвортой, хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, хүн бүрийн бүрэн, үр бүтээлтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой хөдөлмөрийг дэмжих зорилгын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх;
- 10-р зорилт: Ялгаварлан гадуурхах, тэгш бус байдлыг арилгах.

1.2. Монгол Улсын аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн эрхийн хамгааллын хүрээний хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлт

Монгол Улсад АХЭ-тэй хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой харилцааг *Хүснэгт 1*-т заасан хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж байна.

Хүснэгт 1. Хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлт

№	Хууль тогтоомжийн нэр	Анх батлагдсан он	Шинэчлэн найруулсан он	Нэмэлт өөрчлөлт	Тайлбар
1	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль[7]	1996 онд батлагдсан 7 удаа нэмэлт өөрчлөлт орон 2016 онд хүчингүй болсон	2016	1. 2021.04.08 2. 2021.12.17 3. 2021.12.17 4. 2022.04.22 5. 2022.06.28 6. 2024.01.17	(2024.01.17 нэмэлт өөрчлөлтөөр) 5/13 дугаар зүйлийн 13.1.10 дахь заалт: "13.1.10. хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж, батлуулах арга хэмжээ авах." зэрэг 34 зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулсан.
2	Хүүхэд хамгаалллын тухай хууль[8]	2016 онд батлагдан 6 удаа нэмэлт өөрчлөлт	2024	-	**7** бүлэг **59** зүйлтэй

[7] Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль (2016). Хандах: https://legalinfo.mn/mn/detail?lawId=11709. Хандсан огноо: 2025-02-24.
[8] Хүүхэд хамгаалллын тухай хууль (2024). Хандах: https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140463602711. Хандсан огноо: 2025-02-24.

		орон 2024 онд хүчингүй болсон			
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль (хүчингүй)	2005 онд батлагдан 6 удаа нэмэлт өөрчлөлт орон 2016 онд хүчингүй болсон	2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль[9] болсон	1. 2016.09.07 2. 2016.11.10 3. 2021.12.17 4. 2022.04.22 5. 2022.08.29 6. 2023.06.16 7. 2023.07.07 8. 2023.07.07 9. 2023.07.07 10. 2023.12.08	14.3.2.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг тэдний хүйс, оршин суугаа газар, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үл хамааран бүх шатны боловсролд тэгш хамруулах, тухайн хүүхэд, залуучуудын онцлог, хэрэгцээг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, тэдний шаардлагад нийцсэн хичээлийн анги, танхимыг ердийн сургуулиудад зохион байгуулах үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээх гэх мэт тусгайлан хүүхэд гэсэн нийт **14** заалт байна.
4	Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль[10]	2015 онд батлагдсан		1. 2015.12.04 2. 2016.02.05 3. 2016.09.07 4. 2016.11.10 5. 2017.11.10 6. 2021.11.12 7. 2022.11.11 8. 2023.01.06	-5.2. ***Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийг*** нас харгалзахгүйгээр хүүхэд харах үйлчилгээнд хамруулж болно -6.4. Хүүхэд харагч нь бүрэн дүнд болон түүнээс дээш боловсролтой, бага насны, **ХБХ** харилцах, асрах, хүүхдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах, зөв хооллох, бие бялдар, оюун ухааны хөгжлийг дэмжих хүүхэд харах үйлчилгээний тусгай сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан, бага насны хүүхэдтэй харилцах арга зүй эзэмшсэн, халдварт болон сэтгэцийн өвчингүй, эрүүл, гэмт хэрэгт

[9] Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. Хандах: https://legalinfo.mn/mn/detail?lawId=11711 Хандсан огноо: 2025-02-25.
[10] Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль. Хандах:https://legalinfo.mn/mn/detail?lawId=11223 Хандсан огноо:2025-02-26.

					холбогдож байгаагүй, 18-аас 65 насны Монгол Улсын иргэн байна.
5	Боловсролын ерөнхий хууль[11]	2023 онд батлагдсан		1. 2024.01.17 2. 2024.05.16 3. 2024.06.05	3.1.24."ялгаатай хэрэгцээ" гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг хэлнэ зэрэг нийт **12** заалт байна.
6	Эрүүл мэндийн тухай хууль[12]	2011 онд батлагдсан		20 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан	39[1].1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн байнгын хяналтад байж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад АХЭ-тэй хүүхдүүдийн эрхийг хамгаалах, тэдэнд чиглэсэн үйлчилгээг сайжруулах чиглэлээр олон хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж, зарим хуулийг шинэчлэн найруулсан нь эрх зүйн орчныг үе шаттайгаар боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой байна.

[11] Боловсролын ерөнхий хууль (2023). Хандах: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301. Хандсан огноо: 2025-02-25.
[12] Эрүүл мэндийн тухай хууль (2011). Хандах: https://legalinfo.mn/mn/detail?lawId=49. Хандсан огноо: 2025-02-25.

ХОЁР. ЗАРИМ ОРНЫ АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГТЭЙ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХАМГААЛЛЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

2.1. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийг үл алагчлах

Энэхүү судалгаанд хамрагдсан улс орнууд хүүхдийн эрхийн хамгааллын үндсэн хууль тогтоомжоос гадна АХЭ-тай хүүхдийг үл алагчлах зарчмыг хуульд тусгайлсан тусгасан болон Швед Улс Үл ялгаварлан гадуурхах тухай хууль гэсэн бие даасан хуультай байна.

АНУ: Хөгжлийн бэрхшээлтэй Америкчуудын тухай хууль (Americans with Disabilities Act)[13]-иар хөдөлмөр эрхлэлт, боловсрол, төрийн үйлчилгээ зэрэг нийгмийн бүх салбарт АХЭ-тэй хүүхдийг ялгаварлан гадуурхахыг хориглосон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын тухай хуулийн[14] дагуу АХЭ-тэй хүүхдүүдийг аль болох ердийн боловсролын орчинд суралцуулах зорилго тавьж байгаа ба нэг ангид дунджаар нэгээс гурван АХЭ-тэй хүүхэд хамт суралцдаг байна. Муж бүрт ялгаатай дүрэм журам үйлчилдэг учраас хувийн боловсролын төлөвлөгөөний дагуу шийдвэрлэнэ (Education, 2000).

Австрали- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үл ялгаварлан гадуурхах тухай хууль (Disability Discrimination Act)[15] гэсэн тусгайлсан хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үл алагчлагдахаас хамгаалдаг.

2025 оны 2-р сарын 25 нд Аутизмын үндэсний стратеги төлөвлөө (National Autism Strategy 2025-2035)[16]-г боловсруулан АХЭ-тэй хүмүүсийн нийгмийн оролцоо, эдийн засгийн боломж, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахаар зорин ажиллаж байна.

Өмнөд Солонгос- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн тухай хууль (Act on Welfare of Persons with Disabilities)[17]-ийн 8 дугаар зүйлд ялгаварлан гадуурхахыг хориглоно гэж заасан байна.

АХЭ-тэй хүүхдэд зориулсан тусгай сургууль болон ердийн сургуулиудад тусгай ангид бэлтгэгдсэн мэргэжлийн багш нараар тусгай сургалтын үйл ажиллагаа явуулдаг. Мөн АХЭ-тэй болон оюуны бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжиж, бие даан амьдрах чадварыг хөгжүүлэх зорилгоор “хамтын амьдрал” гэсэн хөтөлбөрөөр бусад хүүхэд, хүмүүсийн хамт амьдруулж, өдөр тутмын амьдралд идэвхтэй оролцуулах үйл ажиллагааг зохион байгуулдаг (KCI, 2020).

---

[13] Америк, Americans with Disabilities Act, (1990). хандах: https://www.congress.gov/bill/101st-congress/senate-bill/933. хандсан: 2025.04.07

[14] Америк, Individuals with Disabilities Education Act, 34 CFR § 300.114 (1975). Хандах: https://sites.ed.gov/idea/. Хандсан огноо: 2025-03-25.

[15] Австрали, Disability Discrimination Act (1992). хандах: https://www.legislation.gov.au/C2004A04426/2018-04-12/text. хандсан:2025.04.07

[16] Австрали, About the National Autism Strategy (2025-2035). хандах: https://www.dss.gov.au/national-autism-strategy.
хандсан огноо: 2025.03.25.

[17] Солонгос, Act on Welfare of Persons with Disabilities (2007) [2023], хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=62556&type=part&key=38. хандсан: 2025.04.04

Герман- Тэгш харьцааны тухай хууль (General Equal Treatment Act)[18]-иар нийгмийн бүхий л салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан гадуурхахыг хориглосон. Тус хуулийн дагуу Гэр бүл, ахмад настан, эмэгтэйчүүд, залуучуудын яамны харьяа Ялгаварлан гадуурхалтай тэмцэх агентлагыг байгуулсан. (Federal Anti-Discrimination Agency, 2025)

Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдэд зориулсан тусгай харилцааны платформ (Proloquo2Go)-оор дүрс, текст, дуу хоолой ашиглан харилцдаг (Services, 2023). Мөн АХЭ-тэй хүүхдийн асран хамгаалагчдад зориулсан мэргэжлийн сургалт, зөвлөгөө өгөх хөтөлбөрүүдийг төрийн болон төрийн бус байгууллагууд зохион байгуулдаг.

Их Британи- Тэгш байдлын тухай хууль (Equality Act)[19]-ийн дагуу Хүний эрх тэгш байдлын комисс хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг. Мөн тусгай хэрэгцээт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, эрүүл мэнд, тусламж үйлчилгээний талаарх анхан шатны шийдвэрийг давж заалдах гомдлыг хянан хэлэлцдэг танхимтай байна (GOV.UK, n.d.).

Ерөнхий боловсролын сургуулиудад АХЭ-тэй хүүхдүүдийн боловсролын хэрэгцээг хангах зорилгоор боловсрол, эрүүл мэнд, асрамжийн тусгай төлөвлөгөө боловсруулж, нэмэлт дэмжлэг үзүүлэх мэргэжлийн туслах ажилтан ажиллуулдаг (GOV.UK, 2025).

Швед- Үл ялгаварлан гадуурхах тухай хууль (Discrimination Act (2008:567))[20] бие даасан хуультай. Тэгш байдлын Омбудсмен хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох гомдлыг хянан шийдвэрлэдэг.

АХЭ-тэй хүүхдүүдийн боловсролын хэрэгцээг тодорхойлохын тулд мэргэжлийн багш, сэтгэл зүйчид тухайн хүүхдэд үнэлгээ хийж, тохирсон сургалтын хөтөлбөр боловсруулан, сургуулиудад нэмэлт дэмжлэг үзүүлэх зорилгоор туслах багш, мэргэжилтнүүдийг ажиллуулж, тэдний суралцах үйл явцыг дэмждэг (SPSM, 2023).

Япон- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай хуульд[21] 2024 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох гомдлыг харьяа хүний эрхийн байгууллагууд шийдвэрлэдэг.

Ерөнхий боловсролын сургуульд АХЭ-тэй хүүхдүүдтэй ажиллах туслах багш томилох, тусгай хэрэгцээнд тохирсон сургалтын хөтөлбөр, асран хамгаалчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах зэрэг үйл ажиллагааг хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд зохион байгуулсан.

[18] Герман, General Equal Treatment Act (2006). хандах: https://www.antidiskriminierungsstelle.de/EN/about-discrimination/order-and-law/general-equal-treatment-act/general-equal-treatment-act-node.html. хандсан:2025.04.07.
[19] Их Британи, Equality Act (2010). хандах: https://www.gov.uk/guidance/equality-act-2010-guidance. хандсан: 2025.04.07.
[20] Их Британи, Discrimination Act (2008). хандах: https://www.do.se/choose-language/english/discrimination-act-2008567. хандсан: 2025.04.07.
[21] Япон, Act for Eliminating Discrimination against Persons with Disabilities (2013). Хандах: https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3921.Хандсан огноо: 2025-03-25.

2.2. Хууль эрх зүйн орчин

Судалгаанд авагдсан 7 орноос зөвхөн АНУ АХЭ-ийг зохицуулах бие даасан хуультай байна. Бусад улсын хувьд АХЭ-тэй хүүхдийн эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон бусад холбогдох хуулиар зохицуулж байна.

Хүснэгт 2. АХЭ-тэй холбоотой улс орнуудын хууль тогтоомж

№	Улсын нэр	Үндэсний хууль тогтоомж	Холбогдох зүйл, заалт
1	**АНУ**	**Аутизмын хамтын ажиллагаа, хариуцлага, судалгаа, боловсрол, тусламж үйлчилгээг дэмжих тухай хууль**[22] (Autism Collaboration, Accountability, Research, Education and Support Act)	6 бүлэг 12 зүйлтэй тус хуулиар АХЭ-тэй хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулах, тэдний боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн оролцоог дэмжих зорилготой. -Яс үндэс, угсаа, газарзүйн байршлаас нь үл хамааран эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлнэ.(42 U.S.C. § 284g)
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын тухай хууль[23] (Individuals Disabilities Education Act)	АХЭ-тэй хүүхэд тусгай болон ердийн ангид хамрагдах сонголттой байна (34 CFR § 300.114(a)(2)) .
2	**Австрали**	**Хөгжлийн бэрхшээлээс үүдэн ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хууль**[24] (Disability Discrimination Act 1992)	Боловсрол, хөдөлмөр эрхлэлт болон нийтийн үйлчилгээний салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ялангуяа АХЭ-тэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахыг хориглосон. (sect 4 §1 "*disability*" g)
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний даатгалын системийн тухай хууль[25] (National Disability Insurance Scheme Act)	ХБХ, түүний дотор АХЭ-тэй хүүхдүүдийг зорилгодоо хүрэх, нийгэмд оролцох боломжийг олгох санхүүгийн дэмжлэг, туслалцааг зохицуулсан. (sect 24 *disability requirements*)
		Боловсролын тухай хууль[26] (Education Law)	АХЭ-тэй хүүхдүүд боловсролд тэгш эрхтэй хамрагдаж, сургалтын орчинд шаардлагатай тусламж дэмжлэг авах эрхийг зохицуулсан.(sect 3 § 36)
3	**Өмнөд Солонгос**	**Хүүхдийн эрхийн тухай хууль**[27] (The Child Welfare Act)	Бүх хүүхдийн сайн сайхан байдлыг хангах, тэдний эрхийг хамгаалах

[22] АНУ, Autism Collaboration, Accountability, Research, Education and Support Act (2019). Хандах: https://www.congress.gov/116/plaws/publ60/PLAW-116publ60.pdf. Хандсан огноо: 2025-02-20.
[23] АНУ, Individuals Disabilities Education Act IDEA (1997). Хандах: https://www.govinfo.gov/content/pkg/PLAW-105publ17/pdf/PLAW-105publ17.pdf. Хандсан огноо:2025-02-20.
[24] Австрали, Disability Discrimination Act (1992). Хандах: https://www.legislation.gov.au/C2004A04426/2018-04-12/text. Хандсан огноо: 2025-02-21.
[25] Австрали, National Disability Insurance Scheme Act (2013). Хандах: http://www7.austlii.edu.au/cgi-bin/viewdb/au/legis/cth/consol_act/ndisa2013341/. Хандсан огноо: 2025-02-21.
[26]Австрали, Education Law (2013). Хандах: https://www.education.gov.au/australian-education-act-2013 Хандсан огноо: 2025-02-21.
[27] Өмнөд Солонгос, Child Welfare Act (2014). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=39028&type=sogan&key=10. Хандсан огноо: 2025-02-26.

			хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн халамж, хамгааллыг олгох үүргийг төрийн байгууллагуудад ногдуулах зэргийг зохицуулсан. (artical 3 §5)
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль[28] (The Act on Welfare of Persons with Disabilities)	ХБХ, түүний дотор АХЭ-тэй хүүхдүүдийг ялгаварлан гадуурхахаас хамгаалж, боловсрол, эрүүл мэнд, зэрэг нийгмийн салбарт тэгш боломжийг хангах хүрээг зохицуулсан. (article 2 §(2)(2))
		Тусгай хэрэгцээт боловсролын тухай хууль[29] (The Special education Act for Person with Disabilities)	Тусгай боловсролын хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулсан боловсролын үйлчилгээг зохицуулдаг. (article 8 *Fact-Finding Survey*)
4	**Герман**	**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш боломжийн тухай хууль**[30] (The Equal Opportunities for Persons with Disabilities Act)	ХБХ-ийн нийгмийн бүх салбар дахь тэгш оролцоог хангах, тэдний эрхийг хамгаалах, онцгой хэрэгцээг нь харгалзан бие даан амьдрах боломж олгох зэргийг зохицуулсан. (section1§4)
		Нийгмийн халамжийн тухай хууль[31] (Social Security Code)	Хөгжлийн бэхршээлтэй хүүхдүүдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ, сэргээн засах эмчилгээ, эрүүл мэндийн боловсрол үйлчилгээний талаар зохицуулсан.(section1 §8)
		Хүүхэд, залуучуудын нийгмийн халамжийн тухай хууль[32] (Child and Youth Welfare Act)	Хүүхэд залуучуудын нийгмийн халамж, хамгаалал болон сэтгэцийн эрүүл мэндийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай дэмжлэг, үйлчилгээг зохицуулсан.(section 4 §27-35)
5	**Их Британи**	**Хүүхдийн тухай хууль**[33] (Children Act)	Бүх хүүхдийн эрхийг хамгаалах хууль бөгөөд тус хуульд зааснаар АХЭ-тэй хүүхдийн эрхийн хамгаалах үүргийг орон нутгийн захиргаанд ноогдуулдаг байна. (section 17, section 47)
		Тэгш байдлын тухай хууль[34] (Equality Act 2010)	ХБХ, түүний дотор АХЭ-тэй хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах явдлаас хамгаалж, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ зэрэг бүхий л салбарт тэгш боломжийг хангах зорилготой. (section2 §6,7)

[28] Өмнөд Солонгос, The Act on Welfare of Persons with Disabilities (2007) [2023] Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=62556&type=part&key=38#:~:text=No%20one%20shall%20be%20discriminated,of%20his%20or%20her%20disability. Хандсан огноо: 2025.02.25
[29] Өмнөд Солонгос, The Special education Act for Person with Disabilities (2008) [2023] Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=62719&type=part&key=16. Хандсан: 2020-02-25.
[30]Герман, The Equal Opportunities for Persons with Disabilities Act (2002). Хандах: https://www.rehadat.de/lexikon/Lex-Behindertengleichstellungsgesetz-BGG/. Хандсан: 2025-02-21.
[31] Герман, Social Security Code(1975). Хандах: https://www.gesetze-im-internet.de/sgb_1/. Хандсан огноо: 2025-02-22.
[32] Герман, Child and Youth Welfare Act (1990). Хандах: https://www.gesetze-im-internet.de/sgb_8/index.html#BJNR111630990BJNE006111377 Хандсан огноо:2025.02.23
[33] Их Британи, Children Act (2004). Хандах: https://www.legislation.gov.uk/ukpga/2004/31/contents Хандсан огноо: 2025-02-23.
[34] Их Британи, Equality Act (2010). Хандах: https://www.legislation.gov.uk/ukpga/2010/15/contents Хандсан огноо: 2025-02-24.

6	**Швед**	**Нийгмийн үйлчилгээний тухай хууль**[35] (The Social Services Act)	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, түүний дотор АХЭ-тэй хүүхдүүдэд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, тэдний сайн сайхан байдлыг хангах зорилготой. (section3 §3(a))
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэмжлэг, үйлчилгээний тухай хууль[36] (The Act Concerning Support and Service for Persons with Certain Functional Impairments)	ХБХ тэр дундаа АХЭ-тэй хүүхдүүдэд тусгайлан зориулсан дэмжлэг, нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэхийг зохицуулдаг. (section1 §1)
		Боловсролын тухай хууль[37] (Education law)	Бүх хүүхдүүд болон АХЭ-тэй хүүхдүүдэд тэгш боловсрол эзэмших эрхийг баталгаажуулдаг. Хуульд тусгай хэрэгцээт боловсролын талаар тодорхой заалтууд багтсан бөгөөд сургуулиуд эдгээр хүүхдүүдэд тохирсон боловсролын орчин бүрдүүлэх үүрэгтэй. (section 12)
		Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээний тухай хууль[38] (The Health and Medical Services Act)	ХБХ-ийн эрүүл мэндийн хэрэгцээг хангах, шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхийг зохицуулдаг. (section 5 §6,7)
7	**Япон**	**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндсэн хууль**[39] (Basic Act for Persons with Disabilities)	Хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран бүх иргэдийн хувь хүн бүрийн онцлог, нэр төрийг хүндэтгэн, хүний суурь эрхийг эдлэх эрхтэй хэмээх зарчмын дагуу ХБХ-ийн бие даасан байдлыг дэмжих, нийгэмд оролцох нөхцөлийг хангах үндсэн зарчмуудыг зохицууна. (chapter 2 §14-30)
		Хүүхдийн эрхийн тухай хууль[40] (The Child Welfare Act)	Бүх хүүхдийн сайн сайхан байдлыг хангах, тэдний эрхийг хамгаалах зорилготой бөгөөд аутизмтай хүүхдүүдийн хувьд тохирсон халамж, боловсрол, нийгмийн дэмжлэгийг олгох үүргийг төрийн байгууллагуудад ногдуулах зэргээр зохицуулсан. (chapter 7 § 4(2))

[35] Швед, The Social Services Act (2001). Хандах: https://www.riksdagen.se/sv/dokument-och-lagar/dokument/svensk-forfattningssamling/socialtjanstlag-2001453_sfs-2001-453/ Хандсан огноо: 2025-02-24.
[36] Швед,The Act Concerning Support and Service for Persons with Certain Functional Impairments(1993). Хандах: https://www.riksdagen.se/sv/dokument-och-lagar/dokument/svensk-forfattningssamling/lag-1993387-om-stod-och-service-till-vissa_sfs-1993-387/ Хандсан огноо: 2025-02-24.
[37] Швед, Education Law (2010). Хандах: https://www.riksdagen.se/sv/dokument-och-lagar/dokument/svensk-forfattningssamling/skollag-2010800_sfs-2010-800/. Хандсан огноо: 2025-02-25.
[38] Швед, The Health and Medical Services Act (2017). Хандах: https://www.riksdagen.se/sv/dokument-och-lagar/dokument/svensk-forfattningssamling/halso-och-sjukvardslag-201730_sfs-2017-30/ хандсан:2025.02.25
[39] Япон, Basic Act for Persons with Disabilities (1970) [2011] Хандах: https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2436. Хандсан огноо: 2025-02-26.
[40] Япон, The Child Welfare Act (1947) [2007] Хандах: https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/11/en. Хандсан огноо: 2025-02-26.

		Боловсролын тухай хууль[41] (School Education Act)	Тус хуулийн 7 дугаар бүлгээр тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийн эрхийг хамгаалах, тэдэнд тохирсон боловсролын орчин бүрдүүлэх талаар зохицуулсан. (chapter 7 §72-82)

АНУ-аас бусад улс орнуудад АХЭ-тэй хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж зэрэг салбарын хуулиадаар зохицуулж байна.

2.3. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдэд зориулсан боловсрол

2.3.1. Америкийн Нэгдсэн Улс (АНУ)

Америкийн Нэгдсэн Улс нь НҮБ-аас баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”-д нэгдэн ороогүй учир нь улс төрийн эсэргүүцэл болон дотоодын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг хангалттай гэж үздэг байна.

Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдэд анхан болон дунд шатны боловсрол олгох үйл ажиллагааг “Аутизмын хамтын ажиллагаа, хариуцлага, судалгаа, боловсрол, тусламж үйлчилгээг дэмжих тухай хууль” болон “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын тухай хууль”-ийн дагуу зохицуулдаг тул бусад улстай харьцуулахад харьцангуй нарийн тодорхой байдаг. Боловсролын яам тусгай боловсролын хөтөлбөрийн албаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын тухай хуулийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд хянаж, муж улсуудыг санхүүжилтаар хангадаг.

Боловсролын яам, бага болон дунд боловсролын нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх алба болон тусгай боловсролын албатай хамтран боловсруулсан “Тэгш хамрагдах боловсролын практик” хөтөлбөрийн дагуу дараах боловсрол олгох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг (U.S.Department of Education, 2025).

Хөгжлийн бэрхшээлтэй 3-21 насны хүүхдүүдэд үнэ төлбөргүй нийтийн боловсрол (Free Appropriate Public Education (FAPE)) олгодог. АХЭ-тэй хүүхдүүдэд тус боловсролын үйлчилгээг үзүүлэх хүрээнд тусгайлсан хувийн боловсролын төлөвлөгөө боловсруулна.

Ерөнхий боловсролын сургууль хамран суралцах тойрогт АХЭ-тэй хүүхдийн мэдээллийг бүртгэн, мэргэжилтнээр үнэлгээ хийлгэх, гэр бүлийн ярилцлагын үндсэн дээр хувийн боловсролын төлөвлөгөөг боловсруулна.

Анхан шатны боловсрол

1. Хувийн боловсролын төлөвлөгөө (Individualized Education Program)

(Education, U.S.Department of Education, 2000)

- АХЭ-тэй хүүхдийн боловсролын хэрэгцээнд тохирсон тусгай төлөвлөгөө боловсруулан багш, эцэг эх, сэтгэл зүйч болон бусад мэргэжилтэнтэй хамтран хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон зорилго, аргачлал, дэмжлэгийг тусган сургалтыг зохион байгуулна.

[41] Япон, School Education Act (1947) [2018] хандах: https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4573/en. Хандсан огноо: 2025-02-26.

2. Бага насны боловсролын хөтөлбөр (Early Intervention Services, EIS) (0-3 насны хүүхдүүдэд эрт интервенцийн үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр**)**

- Хэл ярианы эмчилгээ (Speech Therapy)
- Мэдрэхүйн дасгал (Sensory Integration Therapy)
- Сэтгэлзүйн болон зан үйлийн дэмжлэг (Psychological and behavioral Therapy)

3. Тусгай анги (Special Education Classrooms) - Зарим сургууль АХЭ-тэй хүүхдийн суралцах чадварт тохируулан цөөхөн бүлэг, тусгай мэргэжлийн багштай анги нээн хичээллүүлдэг.

4. Хамт олонтой суралцах загвар (Inclusion Model) **–** АХЭ-тэй хүүхдүүдийг ердийн ангиудад хамруулж, тэдэнд зориулсан тусгай арга зүйн техник эзэмшсэн туслах багш дэмжлэг үзүүлдэг.

<u>Дунд шатны боловсрол</u>

1. Хувийн боловсролын төлөвлөгөө болон нэмэлт дэмжлэгүүд- АХЭ-тэй дунд, ахлах ангийн сурагчдын хувийн боловсролын төлөвлөгөөг үргэлжлүүлж, сурагчдын ахиц дэвшлийг тогтмол хянаж, шаардлагатай өөрчлөлтүүдийг тухай бүр хийдэг.

2. 504-р хэсгийн төлөвлөгөө (Section 504 Plan)- Зарим АХЭ-тэй сурагчид тусгай боловсролын сургуульд суралцалгүйгээр ердийн сургуульд нэмэлт дэмжлэгтэйгээр суралцах боломжтой байдаг. Тэдгээр сурагчдад зориулж шалгалтын хугацааг сунгах, шалгалтын үед хэрэглэх нэмэлт хэрэгслээр хангах, хичээлээс түр завсарлага авах, амрах өрөө гаргах зэрэг тусгай хэрэгцээг “Нөхөн сэргээх тухай хууль”[42]-ийн 504 дүгээр хэсэгт зохицуулсан байна.

3. Амьдрах чадвар олгох сургалт (Life Skills Programs) - Зарим дунд сургуулиуд АХЭ-тэй сурагчдад өдөр тутмын амьдрах чадвар олгох тусгай хичээлүүд ордог. Үүнд:

- Нийгмийн харилцааны чадвар;
- Өөрийгөө илэрхийлэх, бие даах чадвар;
- Ажлын ур чадвар гэх мэт.

4. Тусгай сургууль болон сонирхлын хөтөлбөрүүд- АХЭ-тэй сурагчдын онцлог хэрэгцээнд зориулсан тусгай сургууль, мэргэжлийн боловсролын төвүүд байдаг.

5. **Туслан дэмжих технологи** (Assistive Technology) - Харилцааны бэрхшээлтэй сурагчдад зориулсан өргөтгөсөн болон хувилбарт харилцааны (Augmentative and Alternative Communication, AAC) технологиудыг ашигладаг.

АХЭ-тэй хүүхдийн эрхийн хамгаалал

Бүх шатны боловсролын байгууллага нь АХЭ-тэй хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд эцэг эх, багш, мэргэжилтэн, сургуулийн нягт хамтын ажиллагааг чухалчилдаг. Жишээлбэл: Сургуулийн менежер болон удирдлагууд тусгай боловсролын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин, хууль тогтоомжийн шаардлагыг дагаж мөрдөн биелүүлэх үүрэгтэй. Хэрэв хүүхдийн эрх зөрчигдвөл:

[42] Америк, Section504, Rehabilitation Act (1973)[2015] хандах: https://www.dol.gov/agencies/oasam/centers-offices/civil-rights-center/statutes/section-504-rehabilitation-act-of-1973 хандсан огноо: 2025.03.25

- *Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сонсгол*: Эцэг эх, асран хамгаалагчийн гомдлын дагуу сургуулийн дүрэм журмаар 2 талын нотлох баримтын үндсэн дээр сонсголын үйл ажиллагааг явуулна. Хэрэв хүүхдийн эрх зөрчигдсөн тогтоогдвол сургуулийн зүгээс гарсан бүх төрлийн хохирлыг барагдуулах үүрэгтэй.

- *Эвлэрүүлэн жуучлах*: Мэргэшсэн өмгөөлөгчөөр дамжуулан эцэг эх, асран хамгаалагч сургууль хоорондын маргааныг шийдвэрлэх үйлчилгээ.

- *Гомдол гаргах*: Эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс АХЭ-тэй хүүхдийн үнэлгээ, хувийн боловсролын төлөвлөгөөний чанар хүртээмж, тусгай боловсролын үйлчилгээг хангалтгүй, сургуулийн орчинд ялгаварлан гадуурхагдсан гэж үзвэл болох Боловсролын яам, Иргэний тэгш эрхийн алба, шүүх зэрэг дараагийн шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

2.3.2. Бусад орнуудын АХЭ-тэй хүүхдэд зориулсан боловсрол

Австрали, Өмнөд Солонгос, Герман, Их Британи, Швед, Япон улсууд НҮБ-аас баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”[43]-оор хүлээсэн үүргийн дагуу АХЭ-тэй хүүхдүүдэд анхан болон дунд шатны боловсрол олгохдоо нийтлэг тэгш хамруулан сургах сургалтын бодлого, зарчмыг баримталж байна. Үүнд:

1. Тэгш хамруулан сургах боловсрол (Inclusive Education)

- Ердийн сургуулийн орчинд суралцах*:* АХЭ-тэй сурагчдыг ердийн ангид хамруулж, тэдний суралцах үйл явцыг дэмжихийн тулд туслах багш, сэтгэл зүйч, тусгай боловсролын мэргэлтнүүдийн оролцоог хангана.
- Хувийн боловсролын төлөвлөгөө (Individual Education Plan): Сурагч бүрийн онцлог, тусгай хэрэгцээнд тохирсон сургалтын зорилго, хүрэх түвшин, сургалтын арга барил зэргийг тодорхойлж тусгай төлөвлөгөө боловсруулна.

2. Тусгай боловсролын анги, сургууль (Special Education Units and School)

- Тусгай ангиуд: Ердийн сургуулиудад тусгай хэрэгцээтэй сурагчдад зориулсан анги зохион байгуулж, бага бүлгээр сургалтын үйл ажиллагааг явуулна.
- Тусгай сургууль: АХЭ-ийн хүнд хөнгөн хэлбэрээс шалтгаалан тусгай хэрэгцээт сургуулиуд хөгжлийн бэрхшээлийн ангилалд тохирсон хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагаа явуулна.

3. Сэргээн засах үйл ажиллагаа (Therapeutic Services)

- Хэл яриа засал: Харилцааны чадварыг сайжруулах зорилгоор хэл ярианы эмчилгээ болон хэл зүгшрүүлэх сургалт орно.
- Мэдрэхүйн дасгал: Мэдрэхүйн чадварыг дэмжих дасгал хөдөлгөөн, эмчилгээ орно.

4. Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан боловсрол (Parental Support)

- Сургалт, зөвлөгөө: АХЭ-тэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалт, зөвлөгөө өгөх хөтөлбөрүүдийг зохион байгуулна.

[43] United Nations Convention On The Rights Of Persons With Disabilities (2006). Хандах: https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/convention-rights-persons-disabilities. Хандсан огноо: 2025-03-06.

- Мэдээлэл: АХЭ-ийн талаар мэдээлэл, сургалт, зөвлөмж бүхий гарын авлага, вэбсайтууд ажиллуулна.

Дээрх улсууд АХЭ-тэй хүүхдүүдэд боловсрол олгох явцад ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах үндэсний хууль тогтоомжийг үндэслэн хүүхдийн эрхийг хамгаалдаг. Хүртээмжтэй боловсрол олгох бодлогын хүрээнд АХЭ-тэй хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор:

- АХЭ-ийн талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх сургалт сурталчилгааны ажлуудыг зохион байгуулах;
- Сургууль эцэг эх, асран хамгаалагч, тусгай мэргэжилтэн, багш сурган хүмүүжүүлэгчдийн хамтын ажиллагааг сайжруулах ажлуудыг зохион байгуулдаг.

Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд гол төлөв тухайн улсын хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэдэг.

2.3.3. Зарим улсын аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн сургалтын үйл ажиллагааны онцлог

Өмнөд Солонгост хичээлийн дараах хөтөлбөр болох хүүхэд хөгжлийн төвүүдээр дамжуулан АХЭ-тэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сэтгэл зүй, нийгмийн ур чадварыг хөгжүүлэх тусгай хөтөлбөрийн дагуу хичээлийн дараа чадвар ахиулах сургалт зохион байгуулдаг.

Мөн “Солонгосын аутизмын түншлэл” (Autism Partnership Korea) байгууллагаас 2025 оны 3-р сараас “AP school” нэртэй зөвхөн АХЭ-тэй хүүхдүүдэд зориулсан тусгай сургууль нээхээр зорин ажиллаж байна.

Шведэд Зурган харилцааны (Picture Exchange Communication System) платформоор хэл ярианы бэрхшээлтэй, өөрийгөө бүрэн илэрхийлэх чадваргүй хүүхдүүдэд зориулан зургаар дамжуулан харилцах чадварыг хөгжүүлдэг. Мөн сенсор интеграцийн эмчилгээ болох мэдрэхүйн мэдээллийг боловсруулах чадварыг сайжруулах, хөгжүүлэх зорилгоор орчин үеийн техник технологийн тусламжтай эмчилгээ, сургалт явуулдаг.

Германд зан үйлийн шинжилгээ, засал (Applied behavior Analysis, ABA) гэх аргаар АХЭ-тэй хүүхдүүдийн зан үйлийг шинжлэн тогтоох эмчилгээ хийхээс гадна сүүлийн үед хөгжим, амьтан ашиглан сургалт явуулж байна.

Японд АХЭ-тэй хүүхдийн эрүүл мэндийн эмчилгээнд эмэн эмчилгээнээс илүү сүүлийн үеийн технологийн дэвшлийг (робот, анимэ гэх мэт) ашиглан зан үйлийн эмчилгээг хийх явдал нь илүү үр дүнтэй байна.

2.4. Аутизмын хүрээний эмгэгтэй хүний дундаж наслалт

Хөгжингүй орнуудын судалгаагаар АХЭ-тэй хүний дундаж наслалт нь 36-54 нас гэж тогтоогдсон байна (O'Nions, 2023). АХЭ нь амьдралын дундаж наслалтыг бууруулахад нөлөөлөх шууд хүчин зүйл биш ч АХЭ-ийн түвшин, хавсарсан эмгэг (сэтгэл гутрал, зүрх судасны өвчин), эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж, нийгмийн дэмжлэг, боловсролын хүртээмж, ажил эрхлэлт, амьдралын чанар зэрэг олон хүчийн зүйлээс шалтгаалан АХЭ-тэй хүмүүсийн наслалт дундаж наслалтаас бага байна (мөн тэнд).

Хүснэгт 4. АХЭ-тэй хүний дундаж наслалтын үзүүлэлт

№	Улс	Хүн амын дундаж наслалт	АХЭ-тэй хүний дундаж наслалт
1	АНУ	76.4	16-36 жилээр бага
2	Австрали	83.9	20-30 жилээр бага
3	Өмнөд Солонгос	83.5	мэдээлэл байхгүй
4	Герман	81	12-20 жилээр бага
5	Их Британи	81.5	18-30 жилээр бага
6	Швед	83.3	16-30 жилээр бага
7	Япон	85	мэдээлэл байхгүй
8	Монгол	71.5	мэдээлэл байхгүй

Эх сурваж: Word Health Organization (WHO, 2025)

2.5. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээ

2.5.1. Америкийн Нэгдсэн Улс (АНУ)

Сүүлийн үеийн оношилгоогоор тус улсад 35 хүүхэд тутмын нэг нь АХЭ-тэй байна (Drexel, 2025). АХЭ-тэй хүүхдүүдийн нийгмийн халамж, асрахуй, эрүүл мэндийн үйлчилгээг төрийн болон хувийн санхүүжилттай хөтөлбөрүүдээр дамжуулан үзүүлдэг.

АНУ-ын муж улсууд АХЭ-тэй хүүхдүүдэд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэгийг хянахын тулд “Autism Speaks” компани Аутизмын үндэсний мэдээллийн төвтэй хамтран “Autism by the numbers” интерактив хяналтын самбарыг ажиллуулж дараах нийгмийн халамж, эрүүл мэдийн үйлчилгээг үзүүлж байна (Drexel, 2025). Үүнд:

1. Нийгмийн халамжийн үйлчилгээ:

- *Тусгай асаргаа*: Medicaid-аас санхүүждэг өрх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээ (Home and Community-Based Services)-ий Waivers хөтөлбөр нь аутизмтай хүүхдүүдэд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлдэг;
- *Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан асрамжийн газар*: Хүнд хэлбэрийн АХЭ-тэй хүүхдүүд болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүд хамрагддаг.

2. Эрүүл мэндийн даатгал, санхүүгийн дэмжлэг:

- *Медикайд хөтөлбөр (Medicaid)*: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн гэр бүлийн орлогын хэмжээнээс хамаарч олгодог улсын санхүүжилттэй эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр;
- *Хүүхдийн эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр (Children’s Health Insurance Program)*: Бага орлоготой гэр бүлийн хүүхдүүдэд зориулсан хүүхдийн эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр;
- *Хувийн эрүүл мэндийн даатгал (Private Health Insurance)*: Хувийн даатгалын компаниуд АХЭ-ийн эмчилгээний зардлын тодорхой хэмжээг төлдөг.

3. Эрүүл мэндийн үйлчилгээ:

- *Эрт үеийн оролцоо (Early Intervention)*: АХЭ-ийн шинж тэмдгийг 0-3 насанд эрт илрүүлж, оношлон хөгжлийн дэмжлэг үзүүлэх зорилтот хөтөлбөр;

- *Хүүхдийн өсөлт хөгжлийн мэргэжилтний оношилгоо:* АХЭ-ийн мэргэжлийн эмч ононшилж, эмчилгээний тусгай төлөвлөгөөг боловсруулах;
- *Психологийн болон сэтгэлзүйн үнэлгээ:* Хүүхдийн зан үйл, харилцааны чадвар, нийгмийн ур чадварыг үнэлэх;
- *Зан үйлийн шинжилгээ:* АХЭ-тэй хүүхдүүдийн зан үйлийг сайжруулах зорилгоор зан үйлийн шинжилгээ хийх;
- *Хэл ярианы оношилгоо:* Хэл заслын эмч нар хүүхдийн хэл яриа, харилцааны чадварыг оношлох;
- *Мэдрэхүйн оношилгоо:* Мэдрэхүйн чадварыг нь мэргэжлийн эмч нар оношилох;
- *Зан үйлийн эмчилгээ (Applied Behavior Analysis):* Хүүхдүүдийн харилцаа, нийгэмшил, өдөр тутмын ур чадварыг хөгжүүлэх эмчилгээг хийх (долоо хоногт 10-40 цаг);
- *Хэл ярианы эмчилгээ (Speech Therapy):* Дохионы хэл, зургаар ойлголцох, авиа дуурайх төхөөрөмж зэргийг ашиглан харилцааны чадварыг сайжруулах;
- *Хөдөлгөөн засал (Occupational Therapy):* Мэдрэхүйн боловсруулалт, нарийн хөдөлгөөний ур чадварыг хөгжүүлэх;
- *Физик эмчилгээ (Physical Therapy):* Физиотерапевтүүд хөдөлгөөний ур чадварыг сайжруулж, том булчингийн хөгжлийг дэмжих;
- *Эмийн эмчилгээ:* Аутизмтай холбоотой сэтгэл зүйн эмгэг (түгшүүр, анхаарал төвлөрөлт, хэт хөдөлгөөнт байдал)-ыг эмчлэх зэрэг эмийн эмчилгээнд хамруулдаг байна.

2.5.2. Бусад орнуудын аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдэд үзүүлдэг эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ

Австрали, Өмнөд Солонгос, Герман, Их Британи, Швед, Япон улсуудын АХЭ-тэй хүүхдүүдэд үзүүлэх нийгмийн халамжийн тэтгэмж, эрүүл мэндийн үйлчилгээг харьцуулан үзэхэд, АХЭ-ийн эрт илрүүлэг, иж бүрэн оношилгоо, эрт үеийн оролцооны хөтөлбөрөөр ханган АХЭ-ийг эрт илрүүлж, тохирсон эмчилгээнд хамруулж байна. АХЭ-тэй хүүхдэд нийгмийн халамж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд хууль эрх зүйн орчин, халамжийн тогтолцоо харилцан адилгүй ч АХЭ-тэй хүүхдийн хэрэгцээг хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахад эцэг эх, асран хамгаалагч нар чухал оролцоотой байдаг.

Өмнөд Солонгост 4,9,18,30,42,66 сартай хүүхдүүд, ***Шведэд*** бүх бага насны хүүхдүүдийн 95-99%-ийг заавал хамруулж АХЭ-ийн оношилгоо, эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна (Хүснэгт 3). Харин нийгмийн халамжийн тэтгэмжийн дүнгээр ***Германд*** хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж хамгийн өндөр сард 300-900 евро байна. ***Өмнөд Солонгост*** ХБХ-ийн тэтгэмж олгохоос гадна сэргээх засах үйлчилгээний ваучер олгодог. ***Австралид*** 2025 оны 1-р сард “**Аутизмын үндэсний стратеги төлөвлөгөө 2025-2031**”-г боловсруулан АХЭ-тэй хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулахаар нийгмийн оролцоо, эдийн засгийн оролцоо, оношилгоо, эрүүл мэнд гэсэн дөрвөн чиглэлийн хүрээнд бодлого боловсруулан, тус стратегийн хэрэгжилтэд хяналт тавихаар Аутизмын стратегийн хяналтын үндэсний зөвлөл байгуулан АХЭ-т ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байна (Australian Goverment Department of Social Services, 2025).

Хүснэгт 3. Улс орнуудын эрүүл мэнд, нийгмийн халамжийн тэтгэмж

№	Улсын нэр	Эрүүл мэндийн үйлчилгээ	Нийгмийн халамжийн тэтгэмж /ам.доллар/
1	Австрали (Goverment, 2025)	***Оношилгоо, үнэлгээ*** - Эмнэлгийн оношилгоо - Хэл ярианы үнэлгээ - Зан үйлийн үнэлгээ ***Эмчилгээний үйлчилгээ*** - Хэл ярианы эмчилгээ - Мэдрэл сэргээн засах эмчилгээ - Физик эмчилгээ - Зан үйлийн эмчилгээ - Хөгжлийн эмчилгээ ***Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ*** - Сэтгэл зүйн зөвлөгөө - Түгшүүр, сэтгэл гутралын эмчилгээ ***Хөгжлийн дэмжлэг болон тусгай хэрэгцээт үйлчилгээ*** - Эрт үеийн оношилгоо: 0-9 насны хүүхдүүдийн хөгжлийг дэмжих - Тусгай боловсрол - Нийгмийн харилцаа, амьдрах чадвар хөгжүүлэх хөтөлбөр	- ХБХ-ийн тэтгэмж /жилд/ 0-7 нас - 16,700$ (12,525 ам.доллар) 7 ба түүнээс дээш насныханд - 32,800$ (20.654 ам.доллар) - Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулсан орон сууцны дэмжлэг үзүүлдэг. (0-14 насны 125,650 хүүхэд АХЭ-тэй)
2	Өмнөд Солонгос (NHIS, 2025)	***Оношилгоо:*** 4,9,18,30,42,66 сартай хүүхдүүдийг АХЭ-ийн оношилгоонд үнэ төлбөргүй бүрэн хамруулж оношилдог. ***Эрт үеийн оролцооны хөтөлбөр:*** АХЭ-ийг оношилсны дараа хэрэгцээнд нь зориулсан тусгай хөтөлбөр ***Хэл ярианы эмчилгээ*** ***Хөдөлмөрийн эмчилгээ:*** хүүхдэд өдөр тутмын амьдралын ур чадвар, мэдрэхүйг хөгжүүлэх эмчилгээ ***Зан үйлийн эмчилгээ*** ***Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ***.	- ХБХ-ийн тэтгэмж сард 200,000-300,000 вон (137-205ам.доллар) - Сэргээн засах үйлчилгээний ваучер 220,000 воны (165 ам. доллар) нэмэлт санхүүжилт - Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний 50-90%-ийн хөнгөлөлт (38 хүүхэд тутмын нэг нь АХЭ-тэй)
3	Герман (Federal, 2025)	***Эрт илрүүлэг, оношилгоо*:** Хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, АХЭ-ийн шинж тэмдгийн оношилгоог 2-3 насанд нь илрүүлж, шаардлагатай тохиолдолд тусгай мэргэжилтнүүд үзлэг оношилгоог нарийвчлан хийнэ. ***Эмчилгээ, үйлчилгээ*:** АХЭ-тэй хүүхдүүдэд зориулсан сэтгэл зүйн зөвлөгөө, хэл засал, хөдөлгөөн засал зэрэг эмчилгээ, үйлчилгээ ***Асрах үйлчилгээ***: Хэрэв гэр бүлд хүүхдээ асрах боломж хомс бол тусгай асрамжийн төвүүдэд түр хугацаагаар байрлуулах, эсвэл гэрээр асрах үйлчилгээ ***Нийгмийн ур чадварын сургалт***: АХЭ-тэй хүүхдүүдэд нийгмийн харилцааны ур чадварыг эзэмшүүлэх тусгай сургалтуудыг зохион байгуулж өдөр тутмын амьдралд илүү сайн дасан зохицуулах	- Хүүхдийн мөнгө: Сар бүр 219 евро (240 ам.доллар) - ХБХ-д зориулсан тэтгэмж: сар бүр 300-900 евро (330-990 ам.доллар)
4	Их Британи (GOV.UK, 2025)	***Оношилгоо, үнэлгээ:*** 4-6 настайд ***Эрүүл мэндийн үйлчилгээ:*** хэл яриа, хөдөлмөрийн эмчилгээ, хөдөлгөөн засал, зан үйлийн эмчилгээ, сэтгэл зүйн эмчилгээ ***Medicare хөтөлбөр***	- ХБХ-ийн тэтгэмж: 26-101£ /7 хоногт/ (33-131 ам.доллар)

			- Medicare: жилдээ 5 хүртэлх эрүүл мэндийн үйлчилгээний хөнгөлөлт
5	Швед (GOV.Sweden, 2025)	***Эрт илрүүлэг***: нийт хүүхдүүдийн 95-99%-ийг хамруулж, эрүүл мэнд, хөгжлийн үе шатыг эрүүл мэндийн байгууллагаас тогмол хянадаг ***Скринингийн хөтөлбөр***: 3 хүртэлх насны хүүхдүүдийн АХЭ-ийг илрүүлэхэд скринингийн хэрэгслийг ашиглана ***Сэтгэл заслын үйлчилгээ***: АХЭ-ийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тохирсон эрт үеийн оролцооны төлөвлөгөө гарган, сэтгэцийн эмгэг судлалын үйлчилгээнд хамруулна ***Эрүүл мэндийн үйлчилгээ***: АХЭ-тэй хүүхдүүдийн амьдралын чанарыг сайжруулахын тулд хэл яриа, хөдөлмөрийн эмчилгээ, зан үйлийн эмчилгээнд хамруулна.	- ХБХ-ийн тэтгэмж - Хүүхдийн мөнгө
6	Япон (MHLW, 2025)	***Оношилгоо үнэлгээ:*** Нийгмийн эрүүл мэндийн тогтолцооны хүрээнд хүүхдийг 1,5-3 насанд нь сэтгэцийн эмч болон хүүхдийн эмч оношилж АХЭ-ийн үнэлгээ хийнэ. ***Эрт үеийн оролцооны хөтөлбөр***: 6-аас доош насныханд хэл яриа, хөдөлмөрийн эмчилгээ, зан үйлийн хөндлөнгийн оролцооны эмчилгээ үзүүлнэ. ***Сэтгэл зүйн эмчилгээ:*** Мэдрэл, сэтгэл судлалын төв болон тусгай эмнэлэгүүдэд олон талын эмчилгээ үйлчилгээ үзүүлдэг.	- Хүүхдийн мөнгө - 3-аас доош насныханд 15,000¥ (99 ам.доллар) 3-аас дээш насныханд 10,000¥ (66 ам.доллар) - ХБХ-ийн тэтгэмж - сард 15,000¥ (99 ам.доллар) (160 хүүхэд тутмын нэг нь АХЭ-тэй)

2.6. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн гэр бүлд төрөөс олгодог нийгмийн халамжийн төрөл

2.6.1 Америкийн Нэгдсэн Улс (АНУ)

Америкийн Нэгдсэн Улс нь АХЭ-ийн тухай бие даасан хуулийн хүрээнд төрөөс АХЭ-тэй хүүхдийн гэр бүлд санхүүгийн тусламж дэмжлэг, татварын хөнгөлөлт, эрүүл мэндийн үйлчилгээ, гэр бүлийг дэмжих хөтөлбөр, бусад тусламж дэмжлэг гэсэн үндсэн таван ангиллын хүрээнд олон төрлийн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлдэг байна. *(дэлгэрэнгүйг хүснэгтнээс харна уу)*

Хүснэгт 3. АНУ нийгмийн халамжийн төрөл

№	Нийгмийн халамжийн төрөл	Тэтгэмж, үйлчилгээ	Хамрагдах нөхцөл	Тэтгэмжийн хэмжээ
1	Санхүүгийн тусламж дэмжлэг (SSA.gov, 2025)	Аюулгүй байдлын нэмэлт орлого	Орлого багатай гэр бүл	Сард 967$
		Эм, эмчилгээний зардал	Урт хугацааны эмчилгээ шаарлагатай хүүхэдтэй гэр бүлд	Эмчилгээний зардлаас хамаарна
		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмж	Эцэн эх тэтгэвэрт гарсан, хөгжлийн бэрхшээлтэй эсхүл нас барсан тохиолдолд хүүхэд тэтгэмж авна	Эцэг эхийн орлогын хэмжээнээс хамаарна
		Түр тусламж (Assistance, 2025)	Амьжиргааны түвшин доогуур гэр бүлд түр	170$ - 1098$ хүртэлх

			хугацаанд мөнгөн тусламж өгдөг	тэтгэмжийг мужаас тогтооно
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх төрийн хөтөлбөр, тусламж	Мужийн захиргаанаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүлд нэмэлт тэтгэмж олгодог	Муж бүрт харилцан адилгүй
2	Эрүүл мэндийн үйлчилгээ	Medicaid	Бага орлоготой гэр бүлийн АХЭ-тэй хүүхдийг эрүүл мэндийн даатгалд хамруулна	Эрүүл мэндийн даатгалаар
		Хүүхдийн эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр	Бага орлоготой гэр бүлийн хүүхдийн эрүүл мэндийн даатгалд хамруулна	Эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг хөнгөлнө
		Асаргаа сувилгаа	Гэрээр сувилагч, асрагч асрахуйн үйлчилгээ үзүүлнэ	Төрөөс ажилтны цалинг олгоно
		Амралт, чөлөө	АХЭ-тэй хүүхдийн гэр бүлд асаргааны чөлөө, амралт өгдөг	Муж бүрт харилцан адилгүй
3	Гэр бүлийг дэмжих хөтөлбөр	АХЭ-ийн сургалт, зөвлөгөө	Гэр бүлүүдэд АХЭ-ийн талаар сургалт, зөвлөгөө өгнө	Үнэ төлбөргүй
4	Бусад тусламж, дэмжлэг	Орон сууцны түрээс	АХЭ-тэй хүүхэдтэй гэр бүлд орон сууцны татаас өгнө	Түрээсийн хөнгөлөлт үзүүлнэ
		Засвар үйлчилгээ	Тусгай хэрэгцээг хангах гэрийн засвар үйлчилгээнд зориулсан санхүүжилт өгнө	
		Тусгай зөвшөөрөл	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн машинд тусгай зогсоол ашиглах эрх олгоно	Үнэ төлбөргүй ашиглана
5	Татварын хөнгөлөлт	Татвар	АХЭ-тэй хүүхдийн гэр бүл татварын хөнгөлөлт эдэлнэ	3000-6000$ хүртэлх хөнгөлөлт
		Эмнэлгийн зардлын татварын хөнгөлөлт	АХЭ-тэй хүүхдийн эмчилгээний зардлын хөнгөлөлт	Тодорхой дүнг татвараас чөлөөлнө
		Хадгаламжийн данс	АХЭ-тэй хүүхдэд зориулсан хадгаламжийн данс татвараас чөлөөлөгдөнө	17,000$ хүртэлх хадгаламж

Эх сурвалж: USA.GOV (USA.GOV, 2025)

2.6.2 Бусад орнуудын АХЭ-тэй хүүхдийн гэр бүлд төрөөс олгодог нийгмийн халамжийн төрөл

Судалгаанд авагдсан Австрали, Өмнөд Солонгос, Герман, Их Британи, Швед, Япон улсуудын хувьд нийтлэг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” болон нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомж, төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлогын хүрээнд АХЭ-тэй хүүхдээ асран хамгаалж байгаа гэр бүл, асран хамгаалагч нарт нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж байна. Жишээлбэл, Их Британид АХЭ-ээс шалтгаалан сургуульд суралцах боломжгүй хүүхдийн гэр бүлд “Зайнаас сургах сургалтын үйл ажиллагааны тэтгэмж” болох жилд 5,169 фунт стерлинг (6,300 ам.доллар) олгодог. Японд АХЭ-тэй хүүхдээ асарч байгаа эцэг эх, асран хамгаалагчийн хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих зорилгоор “Hello work” хөтөлбөр (богино цагийн ажилд зуучлах)-ийг хэрэгжүүлдэг байна. *(дэлгэрэнгүйг хүснэгтнээс харна уу)*

Хүснэгт 4. Бусад орны нийгмийн халамжийн төрөл

Улсын нэр	Нийгмийн халамжийн төрөл	Тайлбар	Тэтгэмжийн хэмжээ
Австрали (Autism Association of Australia, 2025)	Асаргааны тэтгэмж	АХЭ-тэй хүүхэд асарсны тэтгэмж	144$ /сард/ (92 ам.доллар)
		Ганц бие эцэг эхчүүдэд	1000$/жилд/ (640 ам.доллар)
		Хамтран амьдрагчтай эцэг эхэд	755$ /жилд/ (483 ам.доллар)
	Амралт чөлөө	АХЭ-тэй хүүхдийн асран хамгаалагчид амралт чөлөө олгоно	Даатгалаас санхүүжилт авна
	Түрээсийн хөнгөлөлт	Бага орлоготой гэр бүлүүдэд түрээсийн хөнгөлөлт үзүүлнэ	150-200$ /14 хоногт/ (96-110ам.доллар)
	Татварын хөнгөлөлт	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийг хөнгөлнө	1500-3000$ (960-1920 ам.доллар)
	Тээврийн хөнгөлөлт	АХЭ-тэй хүүхдийн асран хамгаалагчийн тээврийн зардлыг хөнгөлөх	үнэгүй
		АХЭ-тэй хүүхдэд таксины үнийн хөнгөлөлт	50%
	Асран хамгаалачийн нэмэлт тэтгэмж	ХБХ асарсны тэтгэмж	600$/ жилд/ (384 ам.доллар)
Өмнөд Солонгос (MOHW, 2025)	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж	АХЭ-тэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхэд сар бүр санхүүгийн тусламж өгдөг	300,000 вон (228 ам.доллар)
	Хүүхэд асрах тэтгэмж	0-12 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхэд олгох тэтгэмж	400,000-500,000 вон (304-380 ам.доллар)
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах үйлчилгээ	АХЭ-тэй хүүхдүүдийн асран хамгаалагчид зориулсан дэмжлэг	500,000-1,500,0000 вон (341-1023 ам.доллар)
	Асрах үйлчилгээ	Эцэг эхэд амралтын хугацаа олгож хүүхдийг асрамжийн төвд түр байршуулах үйлчилгээ	Үнэгүй болон хөнгөлөлт үзүүлдэг
	Орон сууцны татаас	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүлд орон сууцны хөнгөлөлт үзүүлэх	Түрээсийн хөнгөлөлт болон үнэгүй орон сууцаар хангах
	Тээврийн хөнгөлөлт	Нийтийн тээврийн хэрэгслийг хямд үнээр ашиглах боломжтой	50% хөнгөлдөг
	Гэр бүлд дэмжлэг үзүүлэх	АХЭ-тэй хүүхдийг хэрхэн хөгжүүлэх талаар сургалт, зөвлөгөө өгдөг	үнэгүй
	Асрамжийн тэтгэмж	АХЭ-ийн түвшингээс хамаарч олгоно	316- 901евро (340-971 ам.доллар)

Герман (Federal Ministry of Labour and Social Welfare, 2025)	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг эцэг эхийн эрүүл мэндийн даатгалыг улсаас төлнө	ЭМД-ийн сангаас
	Хүүхдийн нэмэлт тэтгэмж	Бага орлоготой гэр бүлүүдэд зориулсан тэтгэмж	205 евро (221 ам.доллар)
	Асрах үйлчилгээ	Түр хугацааны цалинтай чөлөө болон шаардлагатай үед хүүхдийг асрах үйлчилгээ	1,612 евро /жилд/ (1,738 ам.доллар)
		Хүнд хэлбэрийн АХЭ-тэй хүүхдийг асрамжийн газар асрах үйлчилгээ	1,774 евро /жилд/ (1919ам.доллар)
Их Британи ((DLA), 2025)	Хүүхдийн татварын хөнгөлөлт	Бага орлоготой гэр бүлүүдэд зориулсан нэмэлт тэтгэмж	жилд £545**-** £3,235 (704-4183 ам.доллар)
	ХБХ-ийн тэтгэмж	ХБХ-ийн асаргааны түвшнээс хамаарна	сард £23.70**-**£152.15 (30-196 ам.доллар)
	Асрах үйлчилгээ	Эцэг эх, асран хамгаалагчдад түр хугацааны амралт олгох	Үйлчилгээний төрөл, хугацаанаас хамаарна
	Гэр бүлийн дэмжлэг	Гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл, сургалтын үйл ажиллагаа явуулна	үнэгүй
	Тусгай хэрэгцээт хүүхдийн тэтгэмж	АХЭ-ээс шалтгаалан боловсрол эзэмшиж чадахгүй тохиолдолд зайнаас сургах сургалтын үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэг гэр бүлд олгодог.	Жилд 5,169 $ (6,684 ам.доллар)
Швед (Sweden, 2025)	Хүүхэд асрах тэтгэмж	ХБХ-ийн гэр бүлд зориулсан тэтгэмж	1,250-9,500 крон (124-947 ам.доллар)
	ХБХ-д зориулсан нэмэлт зардлын нөхөн төлбөр	ХБХ-ийн гэр бүлд зориулсан нэмэлт тэтгэмж - Эрүүл мэнд, асаргаа, тусгай хоол тэжээлийн зардал - Аялал - Өдөр тутмын амьжиргааны тусламж - Асаргааны тоног төхөөрөмж	14,700 крон /жилд/ (1,465 ам.доллар)
	Орон сууцны тэтгэмж	АХЭ-тэй хүүхэдтэй гэр бүлд зориулсан хөнгөлөлт	Гэр бүлийн орлогын хэмжээнээс хамаарна
Япон [Autism Society, 2025]	Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх тэтгэмж	20-оос доош насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд олгодог тэтгэмж	Эцэг эхийн орлогоос хамаарна
	Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх тусгай тэтгэмж	АХЭ-тэй хүүхэд өсгөн хүмүүжүүлсний тэтгэмж	33,570-50,400 иен (222-334 ам.доллар)
	Татварын хөнгөлөлт	ХБХ-тэй хүүхдийн гэр бүлийн санхүүгийн дарамтнаас хөнгөвчлөх зорилготой	Эмнэлэг болон ХБ-ийн татвараас хөнгөлнө
	Hello Work	ХБХ-ийн эцэг эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Богино цагийн ажилд зуучилна

	Орон сууцны дэмжлэг	ХБХ-ийн гэр бүлд орон байрны засвар хийх санхүүгийн дэмжлэг үзүүлдэг	-
	Олон нийт, сэтгэл зүйн дэмжлэг	Ашгийн бус байгууллагууд АХЭ-ийн талаар эцэг эхчүүдэд сургалт, зөвлөгөө өгдөг	-

Дээрх улсуудын АХЭ-тэй хүүхдийн гэр бүлд төрөөс хүүхэд асаргааны тэтгэмж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлд олгох дэмжлэгийн тэтгэмж, тусгай тэтгэмж зэрэг олон төрлийн тэтгэмж өгч байгаас Герман Улс хамгийн өндөр асаргааны тэтгэмж болох 340-971 ам.доллар өгдөг байна. Мөн Өмнөд Солонгос, Японд АХЭ-тэй хүүхдийн гэр бүлд сэтгэл зүйн дэмжлэг, АХЭ-ийн талаарх мэдлэг мэдээлэл, сургалт зөвлөгөөг олон нийтийн тусламж дэмжлэгийн хүрээнд үзүүлдэг байна.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд АХЭ-тэй хүүхдийн тоо огцом өсөж байна. 2022 оноос ЭМДЕГ-аас хүүхдийн аутизмын оношилгооны 70 хувийг ЭМД-аас төлдөг болсноор АХЭ-тэй хүүхдийн үзлэг оношилгоо, эрт илрүүлэгт ахиц гарсан.

Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон хүүхдийн эрхийг хамгаалах хуулийн хүрээнд АХЭ-тэй хүүхэдтэй холбоотой нийтлэг болон тусгайлсан зарим зохицуулалтууд байгаа хэдий ч эрүүл мэндийн үйлчилгээ, тэгш хамруулан сургах боловсролын үйлчилгээ, олон нийтэд тус эмгэгийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн дэмжлэгийг сайжруулах нэн шаардлагатай байна. Жишээлбэл, олон улсад 18-24 сартайд нь үзлэг оношилгоо, эрт илрүүлэг хийж оношлон эрт үеийн оролцооны арга хэмжээг авч хэрэгжүүлж байхад манай улсад 3-5 нас хүрсний дараа оношлогдож байгаа ард иргэдийн дунд АХЭ-ийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгааг харуулж байна.

Судалгаанд авагдсан орнуудаас **АНУ** нь АХЭ-тэй хүний эрхийн хамгааллын бие даасан, тусгай хуультай бөгөөд тус хуулийн хүрээнд аутизмтай хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн боловсрол, эрүүл мэнд, АХЭ-тэй хүүхдээ асарч байгаа гэр бүлүүдэд зориулсан хөдөлмөр эрхлэлтийн цогц бодлого, дэмжлэгийн хөтөлбөрүүдийг өргөн хүрээнд хэрэгжүүлдэг байна. Эдгээр арга хэмжээг тасралтгүй шинэчлэн сайжруулж, аутизмтай хүмүүсийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх нь тус улсын урт хугацааны зорилт болсон байна.

Австрали Улсын хувьд; 6 жил тутам хэрэгжих Аутизмын үндэсний стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, үндэсний хяналтын зөвлөл хэрэгжилтэд нь хяналт тавьдаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний даатгалын тогтолцоо нь санхүүгийн өргөн хэмжээний дэмжлэг үзүүлдэг бие даасан халамж, хамгааллын дэд тогтолцоотой байдаг ажээ.

Өмнөд Солонгосын хувьд; Хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэр дундаа АХЭ-тэй хүүхдүүдийг дэмжих төрийн бодлого, хууль эрх зүйн хамгаалалт өргөжиж АХЭ-тэй хүүхдийн оношилгоог 4,9,18,30,42,66 сартайд үнэ төлбөргүй хийн оношилж, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээг цаг алдалгүй хүргэдэг байна. Боловсрол олгох тал дээр тус улсын өрсөлдөөнд суурилсан боловсролын систем нь АХЭ-тэй хүүхдүүдэд хүндрэлтэй байдаг тул хичээлийн дараах тусгай сургалтын хөтөлбөрт хамрагддаг. Мөн 2025 оноос зөвхөн АХЭ-тэй хүүхдүүд суралцах тусгай сургууль нээхээр зорин ажиллаж байна.

Герман, Их Британи, Швед, Япон улсуудын хувьд АХЭ-тэй хүүхдүүдэд боловсрол олгохдоо нийтлэг тэгш хамруулан сургах сургалтын бодлогыг баримталдгаараа төстэй байна.

Япон Улсын хувьд; 160 хүүхэд тутмын нэг нь АХЭ-тэй гэж оношлогдож Өмнөд Солонгоос 5 дахин бага байгаа нь тухайн улсын өвөрмөц нийгэм, соёл, түүхэн уламжлал мөн сэтгэцийн эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн талаарх иргэдийн хандлагаас шалтгаалж байна. АХЭ-тэй хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээнд эмэн эмчилгээнээс илүүтэйгээр сүүлийн үеийн дэвшилтэт технологид суурилсан интервенц буюу хөндлөнгийн оролцоотойгоор зан үйлийн эмчилгээий аргыг хэрэглэдэг. Жишээлбэл, робот, анимэ зэргийг нийгмийн харилцааны сургалт, эмчилгээ, засалд өргөнөөр ашиглаж байна.

НОМ ЗҮЙ

- UNDP. (01 03 2025 г.). United Nations Development Goals. https://www.undp.org/sustainable-development-goals
- Australian Goverment Department of Social Services. (14 01 2025 г.). https://www.dss.gov.au/news/release-national-autism-strategy-2025-31
- Sweden. (13 03 2025 г.). Swedish Social Insurance Agency. https://www.forsakringskassan.se/english/disability
- Autism Society. (2025年03月12日). Tokyo Autism Society. 参照先: https://autism.jp/news_cat/asperger/
- NHIS. (01 03 2025 г.). Korean National Health Insurance Service. https://www.nhis.or.kr/english/index.do
- Federal. (2025). Ministry of Health. https://www.bundesgesundheitsministerium.de/en/index.html
- GOV.UK. (2025). Health and Social Care. https://www.gov.uk/government/news/new-landmark-strategy-to-improve-the-lives-of-autistic-people?utm_source=chatgpt.com
- GOV.Sweden. (2025). Ministry of Health and Social Affairs. https://www.government.se/government-of-sweden/ministry-of-health-and-social-affairs/
- MHLW. (2025). Ministry of Health, Labour and Welfare Japan. https://www.mhlw.go.jp/english/index.html
- MOHW. (2025). Ministry of Health and Welfare. https://www.mohw.go.kr/eng/
- (DLA). (13 03 2025 г.). Disability Living Allowance (DLA) for adults. https://www.gov.uk/: https://www.gov.uk/dla-disability-living-allowance-benefit
- Sweden. (2025). Ministry of Health and Social Affairs. https://www.government.se/government-of-sweden/ministry-of-health-and-social-affairs/
- O'Nions, E. (2023). Estimating life expectancy and years of life lost for autistic people in the UK:a matched cohort study. https://doi.org/10.1016/j.lanepe.2023.100776
- Drexel, U. (2025). The National Autism Data Center. https://nationalautismdatacenter.org/autism-by-the-numbers/
- WHO. (2023). Autism. World Health Organization: https://www.who.int/news-room/fact-sheets/detail/autism-spectrum-disorders
- Монголын Аутизмын Холбоо. (б.д.). Аутизмын хүрээний эмгэг (АХЭ) гэж юу вэ? Монголын Аутизмын Холбоо: https://autism.mn/what-is-autism/
- World Health Organization. (б.д.).
- Federal Ministry of Labour and Social Welfare. (2025). Federal Ministry of Labour and Social Welfare. https://www.bmas.de/EN/Home/home.html
- Autism Association of Australia. (2025). The Spectrum. https://thespectrum.org.au/

- СЭМҮТ. (02 04 2024 г.). Parliament.mn. https://www.parliament.mn/nn/52132/
- НҮБ. (2006). Хөгжлийн бэрхшээлтэй Хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц. https://mlsp.gov.mn/content/detail/1115
- UNESCO. (1994). The Salamanca Statement and Framework for Action. https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000098427
- Education, D. o. (07 2000 г.). A Guide to the Individualized Education Program. https://www.ed.gov/sites/ed/files/parents/needs/speced/iepguide/iepguide.pdf
- KCI. (2020). Perception and Experience of group-homes residential environment by people with mental disorder. https://www.kci.go.kr/kciportal/ci/sereArticleSearch/ciSereArtiView.kci?sereArticleSearchBean.artiId=ART002630116
- Services, U. L. (2023). Advances in technology for deaf communication in Germany. https://www.unspokenasl.com/aslblogs/advances-in-technology-for-deaf-communication-in-germany-2/
- GOV.UK. (2025). Children with special educational needs and disabilities (SEND). https://www.gov.uk/children-with-special-educational-needs/extra-SEN-help
- SPSM. (04 03 2023 г.). Special needs schools. https://www.spsm.se/om-oss/other-languages/english/our-mission/special-needs-schools/
- U.S.Department of Education. (01 2025 г.). BUILDING AND SUSTAINING INCLUSIVE EDUCATIONAL PRACTICES. https://sites.ed.gov/idea/files/Inclusive-Educational-Practices-Guidance-01-16-2025.pdf
- WHO. (2025). Autism. https://www.who.int/news-room/fact-sheets/detail/autism-spectrum-disorders
- SSA.gov. (2025). Family Benefits. https://www.ssa.gov/family
- Assistance, O. o. (2025). An Office of the Administration for Children & Families. https://acf.gov/ofa/map/about/help-families#IL_21815
- USA.GOV. (2025). Find goverment benefits and financial help. https://www.usa.gov/benefit-finder?utm_source=usa_benefits-gov&utm_medium=redirect&utm_campaign=redirect_benefits-gov&modal=b-welcome-189
- Goverment, A. (2025). Services Australia. https://www.servicesaustralia.gov.au/
- Federal Anti-Discrimination Agency. (2025). Federal Anti-Discrimination Agency. https://www.antidiskriminierungsstelle.de/EN/about-us/our-tasks/our-tasks-node.html
- GOV.UK. (2025). First-tier Tribunal (Special Educational Needs and Disability). https://www.gov.uk/courts-tribunals/first-tier-tribunal-special-educational-needs-and-disability
- Education, U.S.Department of Education. (2000). A Guide to the Individualized Education Programm. Editional Publicatoions Center.
- GOV.UK. (б.д.). First-tier Tribunal (Special Educational Needs and Disability): https://www.gov.uk/courts-tribunals/first-tier-tribunal-special-educational-needs-and-disability